



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.Umnugovi@audit.mn](http://www.Umnugovi@audit.mn)

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: Г.Шижирболд  
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	4
<b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан</b> .....	4
<b>2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан</b> .....	4
<b>2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</b> .....	6
<b>2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> .....	7
<b>2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан</b> .....	7
<b>2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан</b> .....	8
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	10
<b>3.1 Албан шаардлага</b> .....	10
<b>3.2 Зөвлөмж</b> .....	11
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	12

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.25 № 223

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХАНБОГД СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ө.УУГАНБЯАР ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нэмэлт зардлаас тэмцээн уралдаан, шагналд 21,994.0 мянга, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн сургалтад 71,240.0 мянга, анхан шатны баримтгүйгээр сэлбэг авахад 8,500.0 мянган төгрөг зарцуулсан нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.7 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас санаачлан Жижиг дунд үйлдвэрлэлийн газартай нөөц сан бүрдүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих чадавхжуулах, сургалт зохион байгуулахаар санамж бичиг байгуулсан байна.

4626050362

F:\2.Бичиг хэрэг\2025\ИТХА-н дүгнэлт\Төсөл.Docx

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 229,600.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл авч бүртгэлд тусгасан байна.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 6 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 83,5 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,761,608.62	2,238,225.30
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	(0.00)
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	(0.00)
3121	Төгрөг	-	(0.00)
31211	Төрийн сангийн харилцах	-	(0.00)
33	АВЛАГА	479,078.86	545,695.54
335	Бусад авлага	479,078.86	545,695.54
3351	Байгууллагаас авах авлага	479,078.86	545,695.54
34	УРЬДЧИЛГАА	42,590,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	42,590,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,692,529.76	1,692,529.76
354	Хангамжийн материал	1,692,529.76	1,692,529.76
35420	Аж ахуйн материал	1,692,529.76	1,692,529.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,423,394.64	227,412,727.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,423,394.64	227,412,727.94
392	Биет хөрөнгө	11,423,394.64	227,412,727.94
39203	Авто тээврийн хэрэгсэл	59,950,000.00	289,550,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(59,950,000.00)	(71,429,999.98)
39205	Машин, тоног төхөөрөмж	29,333,300.00	30,713,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,988,905.09)	(25,176,105.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,515,300.00	12,515,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,436,300.27)	(8,759,766.95)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,450,000.00	2,450,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,450,000.00)	(2,450,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	56,185,003.26	229,650,953.24
413	Өглөг	115,798.49	182,415.17
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	115,798.49	182,415.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	56,069,204.77	229,468,538.07
51	Засгийн газрын хувь оролцоо	56,069,204.77	229,468,538.07
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	9,658,512.00	9,658,512.00
51101	Өмч: -Төрийн өмч	9,658,512.00	9,658,512.00
512	Хуримтлагдсан үр дүн	46,410,692.77	219,810,026.07
51210	Өмнөх үеийн үр дүн	46,410,692.77	46,410,692.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	173,399,333.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	56,185,003.26	229,650,953.24

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
---	----------	----------	------------

Өмнөговь аймгийн Ханбогд сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	493,730,934.00	942,145,716.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	229,600,000.00
3	Нийтлэг татварын бус орлого	-	229,600,000.00
4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	-	229,600,000.00
5	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	493,730,934.00	712,545,716.00
6	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,213,434.00	26,132,816.00
7	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	18,213,434.00	26,132,816.00
8	Орон нутгийн төсвөөс санхүүжих	475,517,500.00	686,412,900.00
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	475,517,500.00	686,412,900.00
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	450,283,612.86	768,746,382.70
11	УРСГАЛ ЗАРДАЛ	450,283,612.86	768,746,382.70
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	360,704,835.87	641,897,491.58
13	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	145,440,912.43	222,484,793.08
14	Цалин	74,761,472.39	97,406,594.83
15	Нэмэгдэл цалин	58,455,428.05	90,044,152.82
16	Урамшуулал	12,224,011.99	35,034,045.43
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,362,299.54	27,207,531.80
18	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,500,781.30	18,501,100.97
19	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,473,326.60	2,176,581.09
20	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	978,444.29	1,328,523.97
21	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	564,659.61	1,088,341.97
22	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,845,087.74	4,112,983.80
23	Хангамж, бараа материалын зардал	50,016,169.74	38,746,350.00
24	Бичиг хэргийн материал	5,720,130.00	4,002,300.00
25	Тээвэр, шатахууны зардал	35,835,305.00	28,005,024.00
26	Шуудан холбоо интернетийн төлбөр	-	1,758,326.00
27	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	4,221,703.00	4,980,700.00
28	Бараа материал актасны зардал	4,239,031.74	-
27	Эд хогшил, урсгал засварын зардал	14,341,500.00	13,081,900.00
28	Урсгал засвар	14,341,500.00	13,081,900.00
29	Томилолт, зочны зардал	1,190,000.00	2,810,000.00
30	Дотоод томилолтын зардал	1,190,000.00	2,810,000.00
31	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	69,558,100.00	250,927,750.00
32	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,558,100.00	250,927,750.00
33	Бараа үйлчилгээний бусад зардал	61,795,854.16	86,639,166.70
34	Бараа үйлчилгээний бусад зардал	51,051,147.80	42,643,000.00
35	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	8,897,310.00	29,005,500.00
36	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,847,396.36	14,990,666.70
37	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,578,776.99	126,848,891.12
38	Бусад урсгал шилжүүлэг	19,398,400.00	11,190,600.02
39	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	10,542,000.00
40	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	19,398,400.00	648,600.02
41	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	68,905,141.07	0.00
42	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,905,141.07	0.00
43	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,275,235.92	115,658,291.10

Өмнөговь аймгийн Ханбогд сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

44	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	115,658,291.10
45	Хөрөнгийн	1,275,235.92	-
46	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	43,447,321.14	173,399,333.30
47	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	43,447,321.14	173,399,333.30

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	493,730,934.00	712,545,716.00
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	493,730,934.00	712,545,716.00
3	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,213,434.00	26,132,816.00
4	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	18,213,434.00	26,132,816.00
5	Орон нутгийн төсвөөс санхүүжих	475,517,500.00	686,412,900.00
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	475,517,500.00	686,412,900.00
7	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	488,219,084.00	711,165,716.00
8	УРСГАЛ ЗАРДАЛ	488,219,084.00	711,165,716.00
9	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,640,307.01	584,316,824.88
10	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	145,772,811.47	222,484,793.08
11	Үндсэн цалин	75,103,371.43	94,461,458.35
12	Нэмэгдэл	58,445,428.05	92,939,590.65
13	Үр дүнгийн урамшуулал	12,224,011.99	35,083,744.08
14	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,362,299.54	27,207,531.80
15	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,500,781.30	18,501,100.16
16	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,473,326.60	2,176,581.90
17	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	978,444.29	1,328,523.97
18	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	564,659.61	1,088,341.97
19	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,845,087.74	4,112,983.80
20	Хангамж, бараа материалын зардал	45,777,138.00	38,746,350.00
21	Бичиг хэрэг	5,720,130.00	4,002,300.00
22	Тээвэр, шатахуун	35,835,305.00	28,005,024.00
23	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,758,326.00
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,221,703.00	4,980,700.00
25	Эд хогшил, урсгал засварын зардал	14,341,500.00	13,081,900.00
26	Урсгал засвар	14,341,500.00	13,081,900.00
27	Томилолт, зочны зардал	1,190,000.00	2,810,000.00
28	Дотоод албан томилолт	1,190,000.00	2,810,000.00
29	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	112,148,100.00	208,337,750.00
30	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	112,148,100.00	208,337,750.00
31	Бараа үйлчилгээний бусад зардал	61,048,458.00	71,648,500.00
32	Бараа үйлчилгээний бусад зардал	52,151,148.00	42,643,000.00
33	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,897,310.00	29,005,500.00
34	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,578,776.99	126,848,891.12
35	Бусад урсгал шилжүүлэг	19,398,400.00	11,190,600.02

**Өмнөговь аймгийн Ханбогд сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан**

36	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	10,542,000.00
37	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	19,398,400.00	648,600.02
38	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	70,180,376.99	115,658,291.10
39	Төвлөрүүлэх шилжүүлэг	68,905,141.07	115,658,291.10
40	Хөрөнгийн	1,275,235.92	-
41	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,511,850.00	1,380,000.00
42	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
43	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,511,850.00	1,380,000.00
44	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,511,850.00	1,380,000.00
45	Дотоод эх үүсвэрээр	5,511,850.00	1,380,000.00
46	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,511,850.00	1,380,000.00
47	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,511,850.00)	(1,380,000.00)
48	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
49	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
50	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(0.00)	-
51	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(0.00)	(0.00)

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,658,512.00		46,410,692.77	56,069,204.77
2025 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	9,658,512.00		46,410,692.77	56,069,204.77
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,658,512.00		46,410,692.77	56,069,204.77
Тайлант үеийн үр дүн			173,399,333.30	173,399,333.30
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,658,512.00		219,810,026.07	219,810,026.07

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	709,772,700.00	570,984,608.90	138,788,091.10	80.45
3	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	709,772,700.00	570,984,608.90	138,788,091.10	80.45
4	Орон нутгийн төсвөөс	709,772,700.00	570,984,608.90	138,788,091.10	80.45
5	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	709,766,700.00	570,984,608.90	138,782,091.10	80.45
6	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	709,766,700.00	570,984,608.90	138,782,091.10	80.45
7	Бараа, үйлчилгээний зардал	691,824,700.00	559,794,008.88	132,030,691.12	80.92
8	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	211,376,400.00	200,518,604.00	10,857,796.00	94.86
9	Үндсэн цалин	97,178,000.00	94,461,458.35	2,716,541.65	97.20

**Өмнөговь аймгийн Ханбогд сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан**

10	Нэмэгдэл	95,198,400.00	92,939,590.65	2,258,809.35	97.63
11	Урамшуулал	19,000,000.00	13,117,555.00	5,882,445.00	69.04
12	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,796,300.00	24,450,904.88	5,345,395.12	82.06
13	Тэтгэврийн даатгал	17,669,500.00	16,626,595.31	1,042,904.69	94.10
14	Тэтгэмжийн даатгал	2,078,800.00	1,956,052.39	122,747.61	94.10
15	ҮОМШӨ ний даатгал	1,663,000.00	978,076.20	684,923.80	58.81
16	Ажилгүйдлийн даатгал	4,157,500.00	978,076.20	3,179,423.80	23.53
17	Эрүүл мэндийн даатгал	4,227,500.00	3,912,104.78	315,395.22	92.54
18	Хангамж, бараа материалын зардал	63,800,000.00	40,126,350.00	23,673,650.00	62.89
19	Бичиг хэрэг	5,800,000.00	4,002,300.00	1,797,700.00	69.01
20	Тээвэр (шатахуун)	42,000,000.00	28,005,024.00	13,994,976.00	66.68
21	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	8,500,000.00	3,138,326.00	5,361,674.00	36.92
22	Ном, хэвлэл	2,500,000.00	-	2,500,000.00	-
23	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	5,000,000.00	4,980,700.00	19,300.00	99.61
24	Нормативт зардал	3,000,000.00	-	3,000,000.00	-
25	Нормын хувцас зөөлөн эдлэл	3,000,000.00	-	3,000,000.00	-
26	Эд хогшил худалдан авах	28,000,000.00	13,081,900.00	14,918,100.00	46.72
27	Тавилга	5,000,000.00	-	5,000,000.00	-
28	Урсгал засвар	23,000,000.00	13,081,900.00	9,918,100.00	56.88
29	Томилолт, зочны зардал	5,000,000.00	2,810,000.00	2,190,000.00	56.20
30	Дотоод албан томилолт	5,000,000.00	2,810,000.00	2,190,000.00	56.20
31	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	241,000,000.00	208,337,750.00	32,662,250.00	86.45
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	241,000,000.00	208,337,750.00	32,662,250.00	86.45
33	Бараа үйлчилгээний бусад зардал	109,852,000.00	70,468,500.00	39,383,500.00	64.15
34	Бараа үйлчилгээний бусад зардал	28,000,000.00	41,463,000.00	(13,463,000.00)	148.08
35	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	81,852,000.00	29,005,500.00	52,846,500.00	35.44
36	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,942,000.00	11,190,600.02	6,751,399.98	62.37
37	Бусад урсгал шилжүүлэг	17,942,000.00	11,190,600.02	6,751,399.98	62.37
38	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	10,542,000.00	10,542,000.00	-	100.00
39	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	7,400,000.00	648,600.02	6,751,399.98	8.76
40	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
41	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
42	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
43	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
44	АЖИЛЛАГСДЫН ТОО	5.00	5.00	-	100.00
45	Удирдах ажилтан	2.00	2.00	-	100.00
46	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00	-	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Тайлант он
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-

Өмнөговь аймгийн Ханбогд сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,902,816.00
3	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,902,816.00
4	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,722,816.00
5	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,180,000.00
6	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,902,816.00
7	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	25,902,816.00
8	Бараа, үйлчилгээний зардал	25,902,816.00
9	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,966,189.08
10	Урамшуулал	21,966,189.08
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,756,626.92
12	Тэтгэврийн даатгал	1,874,504.85
13	Тэтгэмжийн даатгал	220,529.51
14	ҮОМШӨ ний даатгал	350,447.77
15	Ажилгүйдлийн даатгал	110,265.77
16	Эрүүл мэндийн даатгал	200,879.02
17	Бараа үйлчилгээний бусад зардал	1,180,000.00
18	Бараа үйлчилгээний бусад зардал	1,180,000.00
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-
21	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-
22	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-
23	АЖИЛЛАГСДЫН ТОО	5.00
24	Удирдах ажилтан	2.00
25	Гүйцэтгэх ажилтан	3.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 306,242.6 мянган төгрөгийн 5 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 306,242.6 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан.

*Залруулсан алдаа:*

- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгээгүй,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнгээс 258,849.7 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн зардлууд үр дүнгийн тайлангийн зардлаас 4,257.2 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Санхүүгийн байдлын тайланд авлага 545.7 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн,
- Урьдчилж гарсан 42,590.0 мянган төгрөг тайлант хугацаанд хэрэгжсэн боловч тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байна.

Аудитаар нийт 126,169.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 8 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 126,169.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 121,655.8 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

*Илрүүлэлт 1:* Тус байгууллагын ажилтанд эмчийн оношгүй баримтаар эмчилгээ, оношилгооны зардалд зориулан 6,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Илрүүлэлт 2:* Анхан шатны иж бүрдэл дутуу баримтаар 8,500.0 мянган төгрөгийн сэлбэг худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.7-д "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Илрүүлэлт 3:* Төсвийн хөрөнгөөс шагайн харвааны тэмцээнд 17,814.0 мянган төгрөг, шатрын тэмцээн зохион байгуулахад 4,180.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр ...спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Илрүүлэлт 4:* Төсвийн хөрөнгөөс 7,057.2 мянга төгрөгөөр 2 ширхэг мөнгөн аяга худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Илрүүлэлт 5:* Сумын иргэдийн төлөөлөгчдийн сургалтад зориулан нийт 71,240.0 мянган төгрөг зарцуулсан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг ... эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 6: Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 3 алба хаагчийг Даланзадгад суманд болох 3 хоногийн сургалт, зөвлөгөөний дэвтэр, бал, буудал, хоол, шатахуунд зориулан 8,200.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 7: Санхүүгийн тайлангаар 182.4 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт 8: Санхүүгийн тайлангаар 545.7 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:1 Биет хөрөнгөд 2,450.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бүртгэлийн алдааг залруулж санхүүгийн тайлан гаргах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгээгүй	1	-			1	-	1	-				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнгээс 258,849.7 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	258,849.7			1	258,849.7	1	258,849.7				
Мөнгөн гүйлгээний тайлангийн зардлууд үр дүнгийн тайлангийн зардлаас 4,257.2 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	4,257.2			1	4,257.2	1	4,257.2				
Санхүүгийн байдлын тайланд авлага 545.7 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн,	1	545.7	1	545.7			1	545.7				
Урьдчилж гарсан 42,590.0 мянган төгрөг тайлант хугацаанд хэрэгжсэн боловч тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байна.	1	42,590.0			1	42,590.0	1	42,590.0				
<b>ДҮН</b>	<b>5</b>	<b>306,242.6</b>	<b>1</b>	<b>545.7</b>	<b>4</b>	<b>305,696.9</b>	<b>5</b>	<b>306,242.6</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллагын ажилтанд эмчийн оношгүй баримтаар эмчилгээ, оношилгооны зардалд зориулан 6,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна	1	6,000.0			1	6,000.0						
Анхан шатны иж бүрдэл дутуу баримтаар 8,500.0 мянган төгрөгийн сэлбэг худалдан авсан байна	1	8,500.0			1	8,500.0						

Өмнөговь аймгийн Ханбогд сумын ИТХ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

Төсвийн хөрөнгөөс шагайн харвааны тэмцээнд 17,814.0 мянган төгрөг, шатрын тэмцээн зохион байгуулахад 4,180.0 мянган төгрөг зарцуулсан байна	1	21,994.0			1	21,994.0					
Төсвийн хөрөнгөөс 7,057.2 мянга төгрөгөөр 2 ширхэг мөнгөн аяга худалдан авсан байна	1	7,057.2			1	7,057.2					
Сумын иргэдийн төлөөлөгчдийн сургалтад зориулан нийт 71,240.0 мянган төгрөг зарцуулсан байна	1	71,240.0			1	71,240.0					
Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 3 алба хаагчийг Даланзадгад суманд болох 3 хоногийн сургалт, зөвлөгөөний дэвтэр, бал, буудал, хоол, шатахуунд зориулан 8,200.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна	1	8,200.0			1	8,200.0					
Санхүүгийн тайлангаар 182.4 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна	1	182.4			1	182.4					
Санхүүгийн тайлангаар 545.7 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан	1	545.7			1	545.7					
Биет хөрөнгөд 2,450.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байна	1	2,450.0					1	2,450.0			
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>126,169.3</b>			<b>8</b>	<b>123,719.3</b>	<b>1</b>	<b>2,450.0</b>			